



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/658

Хэрлэн сум

Зөвлөх үйлчилгээний зардалд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 2022 оны “Аймгийн 2022 оны төсөвт тодотгол хийх тухай” 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор “Шинэ эрин” олон улсын сургуультай хийсэн менежментийн гэрээний дагуу Бэрх хотын олон улсын хөтөлбөртэй ерөнхий боловсролын сургуульд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн тул холбогдох зардал болох 141,250,000 (нэг зуун дөчин нэгэн сая хоёр зуун тавин мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Шаардагдах хөрөнгийг Засаг дарга дансны Ерөнхий боловсролын сургуульд олон улсын стандарт нэвтрүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ